



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/503

Эрдэнэт

Хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилант сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 а, 29.2 дахь заалт, “Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.7, 4.5.8, 4.5.9 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 32 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулах, улсын чанартай авто замуудад хяналт шалгалтын байнгын пост ажиллуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг I, Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг II, хяналт шалгалтын ажлын зардлыг III хавсралтаар баталсугай.

2.Хяналт шалгалтын хөдөлгөөнт эргүүл, байнгын пост ажиллуулах зардалд 12000000 /арван хоёр сая/ төгрөгийг аймгийн болзошгүй аваарын зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.


3.Хяналт шалгалтын ажлыг 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс 09 дүгээр сарын 23-ны өдөр хүртэл зохион байгуулж, ажлын дүнг танилцуулахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /н.Жигдэнгомбо/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны  
09 дүгээр сарын 05-ны өдрийн  
585 дугаар захирамжийн гуравдугаар  
хавсралт



**ХЯНАЛТ ШАЛГАЛТАНД ЗАРЦУУЛАГДАХ  
ЗАРДЛЫН НЭГДСЭН ТООЦОО**

№	Зардлын төрөл	Нэгж /ширхэг/	Нэгжийн өртөг/төгрөг/	Нэг өдөрт гарах зардал/төгрөг/	Нийт өдөр	Нийт зардал /төгрөг/
1	Ариутгалын зардал	700 тээврийн хэрэгсэл /нэг өдөрт ариутгал хийх/	712.5	285.000	20	5.700.000
2	Сэрэмжлүүлэг, гарын авлага хэвлүүлэх зардал	163 /өдөрт тараах/	150	24.500	20	490.000
3.	Хоолны зардал	8 хүн /өдрийн/	24.000	192.000	20	3.840.000
4	Шатахууны зардал	Хөдөлгөөнт эргүүл	89.500	89.500	20	1.970.000
		Байнгын /пост/	9.000	9.000		
	Нийт					12000000